

## **НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР СУРГУУЛИЙН ГАЗАРЗҮЙН БАГШ З.АМАРЖАРГАЛЫН 2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Газарзүйн багш З.Амаржаргал нь 2018-2019 оны хичээлийн жилд хүүхэд нэг бүрийг газарзүйн хичээлд дур сонирхолтой болгох, тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлыг таниулах зорилготой ажиллалаа. Энэ хүрээнд доорх 4 чиглэлийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулсан.

### **1. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал**

Нийслэлийн ерөнхий боловсролын Лаборатори 23-р сургууль нь 2018-2019 оны хичээлийн жилийн I улирлаас GREEN I<sup>S</sup>LAND төслийн хүрээнд хэрэгжүүлж буй олон улсын Эко сургууль хөтөлбөрт хамрагдаж, сургуулийн эко зөвлөл байгуулагдсан.

Эко зөвлөлийнхөн доорх сургалтуудад хамрагдан дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. 2018.10.19-20-ны өдрүүдэд анхан шатны 1 дэх сургалтыг өөрийн сургууль дээр зохион байгуулсан бөгөөд сургалтанд нийслэлийн 23-р сургууль, Наран сургууль, Монгол тэмүүлэл сургууль, Шинэ Монгол сургууль, Hobby сургууль, Төв аймгийн Ү сургуулийн багш сурагчидтай хамтран “Орон нутгийн хүрээлэн буй орчны төлөв байдлыг үнэлэх” дадлага ажлыг гүйцэтгэсэн бөгөөд 1-р хэсэгт Газарзүйн мэдээллийн систем дээр ажиллан УЛААНБААТАР ХОТЫН ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ-г хийсэн. Мөн “Орон нутгийн хүрээлэн буй орчны төлөв байдлыг үнэлэх” дадлага ажлын 2 -р хэсэгт 23-р сургуулийнхаа гадаа талбайд ХӨРСНИЙ ШИНЖИЛГЭЭ хийж дүгнэлт гаргасан. Сургалтын дараа сургуулийн эко клубыг шинэчлэн 7-10-р ангийн 42 сурагчийн бүрэлдэхүүнтэй байгуулж, анхан шатны сургалтыг Эко клубын 42 сурагч болон 80 гаруй багшид зохион байгуулж, Чингэлтэй орон нутгийнхаа орчны төлөв байдлыг үнэлэх судалгаа тайлан хийж Шинэ монгол сургууль дээр танилцуулга хийсэн
2. 2018.11.15-16-ны өдрүүдэд анхан шатны 2 дахь сургалт Шинэ Монгол сургууль дээр зохион байгуулагдсан. Уур амьсгалын өөрчлөлтийн талаар сургалтанд хамрагдсанаас гадна тухайн сургуулийн орчны үнэлгээ хийх багт орж ажиллалаа. Сургалтын үр дүнд сургууль дээрээ 2018.12.08-ны өдөр СУРГУУЛИЙН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ хийх сургалтаа зохион байгуулж 7 багт хуваагдан, 23-р сургуулийнхаа гадаад, дотоод орчны үнэлгээ, план зураглалыг гаргаж, Наран сургууль дээр тайлангаа тавьсан.
3. 2018.12.14-15-ны өдрүүдэд Наран сургууль дээр олон улсын эко сургууль хөтөлбөрийн 3 дахь шатны сургалтанд хамрагдаж тухайн сургуулийн орчинд НҮҮРСХҮЧЛИЙН УЛ МӨР-ийг судлах багт орж ажилласан.

4. Мөн Эко зөвлөлийн салбар болж сургуулийн ЭКО КЛУБ, БОРДОО БЭЛТГЭХ БАГ, НОГООН ПАСПОРТ АЯНЫ БАГ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БҮЛГЭМ зэрэг багууд хамтран ажиллаж байна. Бүлгэмүүдийн хийсэн ажлаас товч дурьдвал:

-Тогтвортой хөгжил бүлгэмийн 11-р ангийн 35 сурагч 1 багшийн хамт Сэлбэ голын сав дагуу хогийг цэвэрлэх, урсацыг тодорхойлох экскурс судалгааг зохион байгуулсан.

-Тус сургууль Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний төвтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд 10 сурагч, 2 багшийн бүрэлдэхүүнтэй хүнсний хаягдлаар бордоо бэлтгэж, бордоогоороо ахуйн нөхцөлд тасалгааны цэцгийг бордох туршилт ажлыг амжилттай хэрэгжүүлж Нийслэлийн жишиг 5 сургуулийн дунд зохион байгуулсан “Бордоо бэлтгэх арга технологи” уралдаанд II байр эзэлсэн.

-Хогийг ангилан ялгах зорилготой сурталчилгааны ханын сонин, зурагт хуудсыг давхруудад байршуулж, мэдээлэл өгч байгаа.

-2018.11.20-нд Хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний төвийн мэргэжилтнүүдтэй хамтран Эко клубын 30 сурагчид сургалт зохион байгуулсан.

-2019 оны 02 сарын эхээр 23-р сургуулийнхаа Нүүрсхүчлийн ул мөрийг тодорхойлох судалгааг хийсэн. Судалгаа нь 3 хэсгээс бүрдсэн бөгөөд сургуулийн орчинд ялгарч байгаа хог хаягдал,эрчим хүчний хэрэглээ, тээврийн хэрэгслийн судалгааг сургуулийн нийт багш нарт сургалт явуулсны үндсэн дээр багш нар болон эко зөвлөл, клубынхээ сурагчидтай хамтран хийсэн.

Эко зөвлөлийнхөн судалгаа хийсний үндсэн дээр төсөл боловсруулж, хогийн савны макет, үзэсгэлэн гарган Ротаричуудын өдөрлөгт танилцуулж Шаркуудаас дараах хөрөнгө оруулалтыг сургуульдаа оруулж чадсан.

Энэхүү хөрөнгө оруулалтаараа сургуулийн гадна орчинд хогийн саваа байршуулсан бөгөөд хогийн савны орчинд доорх зүйлсийг байршуулахаар ажиллаж байна.

2. Дэгийн хэрэгжилт, дадал хэвшил суусан байдал

7б анги 50 сурагчтай бөгөөд сургуульд мөрдөж буй дэгүүдийг хичээлийн жилийн эхэнд сурагчиддаа танилцуулж, хэвшүүлж ажилласнаар хичээллэх үед мэргэжлийн багш нарт хүндрэл учрахгүй, завсарлагааны минутыг дэг журамтай өнгөрүүлэхээр хичээн ажиллаж байна. Тухайлбал 4-р цагийн завсарлагаанаар гимнастик хийж хэвшсэн.

3. Бусадтай харилцах зан чанар

Нийт газарзүйн хичээл судалдаг сурагчдаа багштайгаа болон ангийнхантайгаа нээлттэй харилцдаг, үзэл бодлоо илэрхийлдэг, цаг баримталдаг, хариуцлагатай зан чанарт сургахаар хичээн ажилласан. 7б ангийн сурагчдын тухайд хүлээцтэй зан чанарт сургахаас гадна Талархлын баярын хүрээнд баярлалаа, намайг уучлаарай сэдэвт ажлыг зохион

байгуулж ханын самбар гаргасан.

4. Сурагчдын оролцооны ур чадварын хөгжил, дадал хэвшил зан чанарын байдал  
Ахлах ангийн сурагчдыг Тогтвортой хөгжлийн боловсролын талаар ойлголттой, тодорхой хувь нэмэр оруулахуйц иргэд бэлтгэх чиглэл барьж ажиллалаа. Энэ хүрээнд сургуулийн Эко зөвлөлд 11-р ангийн 5 сурагч орж жилийн турш идэвхтэй үйл ажиллагааг биечлэн зохион байгуулсан. Мөн багаар ажиллаж Байгаль орчинд тулгамдсан асуудлын талаар судалгаа хийж, илтгэл бэлтгэн цаашид гарах арга зам шийдлийн талаар хэлэлцүүлэг хийсэн.
5. Жижүүр багшийн үнэлгээ  
9-5-р сарын хооронд сар бүр жижүүр багшийн үүргийг хариуцлагатай гүйцэтгэж 28-30 оноотой дүгнэгдсэн.
6. Хэдэн судалгаа хийсэн, ямар үр дүнд хүрсэн эсэх, ажилласан байдал  
7б ангийн сурагчдаас дэлгэрэнгүй судалгаа, автобусаар зорчих судалгаа, эрсдлийн бүлгийн судалгаа, сонирхлын судалгаа, эцэг эхийн хандлагын судалгаа зэрэг нийт 5 судалгаа авсан байна. Судалгааны үр дүнд тулгуурлан сурагчдыг дугуйлан сонгонд хамруулан, анхаарал татсан сурагчдын эцэг эхтэй хамтран төлөвшил, хүмүүжил дээр ахиц гаргах талаар анхаарал тавин ажилласан.
7. Эцэг эхийн оролцоо, хичээлээс гадуурх хүмүүжлийн ажлын үр дүн  
Ангид эцэг, эхчүүд 4 багт хуваагдан улиралд бүрд явагдах хичээлээс гадуурх хүмүүжлийн ажлыг дэмжин оролцсон.  
Ангийн эцэг, эхийн зөвлөлийн дарга Б.Мягмаржав сургуулиас зохион байгуулсан “Эцэг эхийн зөвлөгөөн”-д сонирхолтой сэдвээр илтгэл тавьсан бөгөөд зөвлөгөөний үйл явц ба илтгэлээ ангийн эцэг, эхчүүддээ танилцуулан хэлэлцүүлэг хийлээ.  
Хичээлийн жилийн туршид эцэг, эхийн уулзалт зөвлөгөөнийг 6 удаа зохион байгуулсан бөгөөд ангийн эцэг, эхийн төлөөлөл 4 хүн MOODLE системийн сургалтанд, 2 эцэг, эх ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨГӨӨН-д, 8 эцэг, эх АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ сургалтанд хамрагдаж эргэх холбоогоор ангийн эцэг, эхчүүддээ сургалт зохион байгуулсан байна. Мөн эцэг, эхчүүдээс хандлагын судалгааг авсан.
8. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн биелэлт  
Сургуулийн нийгмийн ажилтантай хүүхэд хамгааллын ёс зүйн гэрээ байгуулж, эрсдлийн бүлгийн судалгааны үр дүнд тулгуурлан эцэг, эхчүүдтэй холбоо тогтоон ажилласан.
9. Гранд дизайны зорилго, зорилтын биелэлт  
Гранд дизайн-23 т тусгагдсан зөв дадал хэвшилтэй, зөв хандлагатай, бие даан өөрийгөө хөгжүүлдэг хүүхдийг бэлтгэх зорилгоор дааж ажилладаг 7б анги болон хичээл ордог сурагчдыг чиглүүлэн ажилласан. Мөн цаг баримталдаг байлгахар ангидаа олон үйл ажиллагааг өрнүүлж, эцэг эхтэй нь хамтран ажилласнаар 7б анги “Хоцрогч, таслагчгүй хамт олон” уралдаанд 11-р сард дэд байр, I хагаст III байр, III улиралд тэргүүн байр эзэлсэн.

## I. Мэдлэг чадвар ахиц, амжилт

### 1. Гарааны болон Оношлох үнэлгээ

#### 3.1 Стандарт хэрэгжилт

#### ГАЗАРЗҮЙН СУДЛАГДАХУУНЫ МЭДЛЭГ ЧАДВАРЫН СОРИЛЫН ДҮГНЭЛТ

АНГ И	БҮЛЭ Г	дүгнэгдэх	дүгнэгдсэн	ҮНЭЛГЭЭНИЙ ТҮВШИН							
				ҮIII	ҮII	ҮI	Ү	IV	III	II	I
7	Б	52	52	5	18	10	16		1		2
	НИЙТ	52	52	5	18	10	16		1		2
9	А	49	47	22	12	13					
	В	43	43	13	13	5	5	5	2		
	Д	46	46	17	14	6	9				
	НИЙТ	138	138	52	49	24	14	5	2		
11	А	41	41	10	10	9	5	2	1	3	1
	Б	39	39	7	13	9	8		1	1	
	В	53	53	14	15	7	13	1	2	1	
	Г	45	45	7	7	13	8	6	4		
	Д	52	52	14	19	10	5	1	1		2
	НИЙТ	230	230	52	64	48	36	10	9	5	3
НИЙТ		420	420	109	131	82	76	15	12	5	5

Нийт сурагчдын үнэлгээг харьцуулж үзвэл ҮII-ҮIII түвшинд 240 сурагч буюу шалгуулагчдын 5.7 хувь, I-III түвшинд 22 сурагч буюу шалгуулагчдын 5.2 хувь үнэлэгдсэн байна. Иймээс сул үнэлгээтэй дүгнэгдсэн сурагчдыг анхааран цаашид эзэмшиж буй мэдлэгээ өөрийн болгож дадал, чадвар болгож хөрвүүлэх чадвартай болгоход анхаарч ажиллана.

#### 3.2 ГАЗАРЗҮЙН СУДЛАГДАХУУНЫ I ХАГАС ЖИЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТҮВШИН


АНГ И	БҮЛЭ Г	дүгнэгдэх	дүгнэгдсэн	ҮНЭЛГЭЭНИЙ ТҮВШИН							
				ҮIII	ҮII	ҮI	Ү	IV	III	II	I
7	Б	52	52	5	18	10	16		1		2
	НИЙТ	52	52	5	18	10	16		1		2
8	А	44	44	16	14	11	3				
	Б	39	39	18	11	5	2	2	1		
	В	56	56	15	18	15	8				
	Г	44	44	14	11	6	13				
	Д	57	57	16	9	18	14				
	НИЙТ	240	240	79	63	53	40	2	1		
9	А	49	47	22	12	13					
	В	43	43	13	13	5	5	5	2		
	Д	46	46	17	14	6	9				
	НИЙТ	138	138	52	49	24	14	5	2		
11	А	41	41	10	10	9	5	2	1	3	1
	Б	39	39	7	13	9	8		1	1	
	В	53	53	14	15	7	13	1	2	1	
	Г	45	45	7	7	13	8	6	4		
	Д	52	52	14	19	10	5	1	1		2
	НИЙТ	230	230	52	64	48	36	10	9	5	3
НИЙТ		660	660	188	194	135	116	17	13	5	5



Суурь ба бүрэн дунд боловсролын нийт 660 сурагчид дүгнэгдсэн бөгөөд үнэлгээний журам шинэчлэгдэж 8 түвшний үнэлгээг ашиглах болсонтой холбогдон Мэдлэг чадварын сорил буюу эцсийн үнэлгээний шалгалтаар I хагас жилийн үнэлгээг гаргасан бөгөөд сорилд хамрагдаагүй 8 дугаар ангиудын сурагчдын үнэлгээг явцын нэгжийн шалгалтын дундаж үнэлгээгээр тооцож гаргасан болно. Сурагчдын шалгалтын бэлтгэл харилцан адилгүй байсан бөгөөд асуулт даалгавар болон бүтээх даалгавар, бодлого бодох гэсэн үндсэн чиглэлийн даалгаврууд дээр ажилласан.

**ГАЗАРЗҮЙН СУДЛАГДАХУУНЫ IY УЛИРАЛ БУЮУ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
ҮНЭЛГЭЭНИЙ ТҮВШИН**

АНГИ	БҮЛЭГ	дүгнэгдэх	дүгнэгдсэн	ҮНЭЛГЭЭНИЙ ТҮВШИН							
				YIII	YII	YI	Y	IY	III	II	I
7	Б	50	50	22	18	9	1	0	0	0	0
	НИЙТ	50	50	22	18	9	1	0	0	0	0
8	А	44	44	17	22	5	0	0	0	0	0
	Б	40	40	18	12	5	5	0	0	0	0
	В	52	52	18	28	6	0	0	0	0	0
	Г	44	44	16	11	11	6	0	0	0	0
	НИЙТ	180	180	69	73	27	11	0	0	0	0
9	А	47	47	24	23	0	0	0	0	0	0
	В	43	43	17	18	8	0	0	0	0	0
	Д	44	44	23	21	0	0	0	0	0	0
	НИЙТ	134	134	64	62	8	0	0	0	0	0
11	А	41	41	30	9	2	0	0	0	0	0
	Б	39	39	24	13	2	0	0	0	0	0
	В	53	53	35	16	2	0	0	0	0	0
	Г	46	46	31	11	3	1	0	0	0	0
	Д	53	53	36	14	3	0	0	0	0	0
	НИЙТ	232	232	156	63	12	1	0	0	0	0
НИЙТ		596	596	311	216	56	13	0	0	0	0



Үнэлгээнээс харахад 9 ба 11 дүгээр ангийн үнэлгээний түвшин өндөр байгаа нь сурагчдын идэвх оролцоо сайн, үүрэг хариуцлагаа ухамсарласантай холбоотой.

Хичээлийн жилийн төгсгөл хэсэгт 11-р ангиас Мэдлэг чадварын сорил шалгалтыг Газарзүйн хичээлээр авсан бөгөөд нийт сурагчдын гүйцэтгэл 91,69 %-тай дүгнэгдсэн байна. 9-р ангийн Байгалийн ухааны нэгдмэл шалгалтыг 86 сурагч сонгон өгсөн байна. 9-р ангийн Улсын шалгалтын бэлтгэл хийж “Эртэч хүүхэд” аяны хүрээнд 9а, 9в, 9д ангийн сурагчдад 6 удаагийн давтлага өгснөө гадна шалгалтын өмнө дахин 14 хоногийн хугацаанд Газарзүйн багш Г.Энхтуултай хамтран 6 өглөө давтлага өглөө. Мөн 12-р ангийн ЭЕШ өгөх 5 сурагчдад Сарын хугацаанд давтлага өгч, МУБИС, Ерөнхий боловсролын газарзүйн багш нарын холбооны хамтран зохион байгуулсан 14 хоногийн эрчимжүүлсэн сургалтанд хамруулсан. Тухайн сургалтанд 1 өдрийн сургалтыг МУБИС дээр 30 сурагчдад сургалт зохион байгуулсан.

2. Улирал бүрийн нэгж хичээлийн боловсруулалт /MOODLE/  
2018-2019 оны хичээлийн жилийн II улирлын амралтаар MOODLE системийн сургалтанд сууж, III улирлаас эхлэн хичээлийн агуулга, үнэлгээний шалгуурыг оруулсан болно.
3. Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт  
Хичээлийн жилийн эхэнд өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөг гаргаж, нийт төлөвлөсөн ажлууд 96% биелэлттэй байна.
4. Судлагдахууны хөтөлбөрийн үр дүн  
Газарзүйн хичээлийн жилийн төлөвлөлт болон нэгж хичээлийн хөтөлбөрийг боловсруулан ээлжит хичээлийн үйл ажиллагааг төлөвлөн, цахим хичээлийн сан бүрдүүлэн ажилласны үр дүнд 11-р ангийн мэдлэг чадварын сорил шалгалт болон 9-р ангийн байгалийн ухааны улсын шалгалтанд амжилттай дүгнэгдсэн.
5. Журнал бичилт  
Сурагчдын ирц болон ээлжит хичээлийн үйл ажиллагаа, үнэлгээ-1, үнэлгээ-2 хэсгийг зааврын дагуу бөглөсөн.
6. Хичээлд ордог сурагчдын хүртээмж  
Нийт 14 ангид Газарзүйн хичээл орсон. 7б, 8а,б,в,г, 9а, в,д ангиудад долоо хоногт 1 цагаар, 11а, б, в, г, д ангид долоо хоногт 2 цагаар нийт... сурагчид хичээл заалаа.
7. Багшийн хөгжлийн дэвтрийн хөтлөлт  
Хичээлийн зорилго, зорилт, гранд дизайн, хийх ажлын төлөвлөгөө, 9-6-р сарын хоорондох хичээллэсэн өдөр бүрийн төлөвлөгөө, гүйцэтгэл, хамтын ажиллагааны тэмдэглэл, асуудлын хэсэг, шинэ санааны булан, өөрийгөө хөгжүүлэхээр суусан сургалтын, ажлын тэмдэглэл зэргийг тухай бүрд нь тэмдэглэсэн.
8. Хүүхэд бүрийн ахиц амжилтанд нөлөөлсөн бүтээлч ажил  
Хүүхэд 1 бүрийг хөгжүүлэх ахиц, амжилт гаргах зорилгоор ээлжит хичээлийг үр дүнтэй өнгөрүүлж, сурагчдыг сонирхлыг төрүүлсэн бүтээлч бие дааах ажлуудыг хийлгэж, хийсэн ажлын үр дүнгээ багаараа танилцуулж, бүтээлийн үзэсгэлэн гаргасан нь орлцоог дэмжсэн үйл ажиллагаа болсон гэж үзэж байгаа. Мөн 7, 8, 9-р ангийн сурагчид дэлхийн болон монгол орны дасгалын зурагт нэгжийн агуулгын дагуу тэмдэглэл хийж дэвтрээ хавтаслаж хэвшсэн

нь сурагчдын газарзүйн зурагтай ажиллах чадвар болон бүтээлч сэтгэхүйг дэмжсэн ажил болсон.

9. Сурагчдын сурах үйлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж байгаа байдал

Сурагчдын дийлэнх нь оролцоо сайтай хэдий ч дунд ангиудад анги тус бүрд хоцрогдож буй 3-6 сурагч байна. Энэ нь сурах арга барилд суралцаагүй, хүүхдийн тоо олонтой холбоотойгоор багш нар бүх хүүхдэд тухай бүрт хүрч ажиллах боломж багатай, сурагчдын залхуу байдалтай холбоотой. Мөн ахлах ангийн сурагчид хичээлээс гадуурх үйл ажиллагаанд их оролцдог, сурагч тэмцээн уралдаанд олон өдрөөр оролцдог, зарим нэг сурагч цагаар хичээл тасалдаг нь хичээлийн хоцрогдол үүсэх үндсэн шалтгаан болдог.

## II. Авьяасыг нээн судлах хөгжүүлэх


- ✓ Сонирхлын судалгаа

Хичээлийн жилийн эхэнд ангийн сурагчид өөрсдийн зорилгоо тодорхойлж, өөрийн хөгжлийн төлөвлөгөөг гаргасан. Мөн сурагч бүр хүсэл мөрөөдлийн зурагт хуудсаа хийж ирээдүйн ажил мэргэжлийнхээ чиг баримжаатай болж байгаа.

- ✓ Дугуйлан секцэд хамрагдсан сурагчдын судалгаа /танхим ба танхимын бус

Сурагчдаас өөрийн сонирхлын дагуу хаана, ямар сонгон дугуйланд хамрагдах сонирхолтой талаар ярилцаж, эцэг эхийн дэмжлэгтэйгээр сургууль дээр болон бусад газруудад ангийн сурагчдын 54% буюу давхардсан тоогоор 37 сурагч дугуйланд хамрагдаж байна. Үүнээс дийлэнх хувийг математик сэтгэлгээ, Япон хэлний Гэрэлт тайёо болон Цүбоми сургалтын төвүүдэд хамрагдсан. Мөн өөрийн сонирхлын дагуу жудо бөх, сагс, гар бөмбөг, уран нугаралт, усан спорт, хөл бөмбөг, теннисний дугуйлангаас гадна англи хэл, Монголын хүүхдийн ордон, Хүүхдийн урлан бүтээх төвийн уран зураг, баримлын ангиудад хичээллэж байна.

Дугуйлан секцэд хамрагдсан байдал



- ✓ Ангийн номын сангийн баяжилт

Ангидаа явуулын номын уншлагыг зохион байгуулж байгаа бөгөөд Чингэлтэй дүүргийн хэмжээнд сурагчдын зайлшгүй унших “Усан доогуур 20000 бээр аялсан нь”, “Алтан цох” зохиолуудыг уншсан. Сургуулийн цахим номын санд 17 ш номыг хандивласан.

- ✓ Уншсан номын тэмдэглэл хөтөлсөн эсэх

1. Японы зохиолч Сайшо Хирошигийн “Өглөөний хүн” [Цаг хугацааг захирах нь...] зохиолыг ангиараа өглөөний уншлага хийсэн нь сурагчид өглөө эртлэн босож хэвшихэд нөлөөлсөн үр дүнтэй үйл ажиллагаа болсон..

2. Жамбалсүрэнгийн Золбаярын “Амьдрал сайхан шүү” номыг уншиж тэмдэглэл хөтлөн хэлэлцүүлэг хийсэн.

- ✓ Бүтээлийн үзэсгэлэн гаргасан байдал  
Хичээлийн жилийн туршид 3 удаа сурагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргалаа. 8-р ангийн сурагчид “Геологийн хөгжил, газрын гадарга” нэгжийн хүрээнд Хаяалбар шугам сэдвээр, сургуулийн эко зөвлөл “Хог хаягдлыг ангилан ялгах” чиглэлээр Ротаричуудын уулзалт дээр, 2019.04.22-ны Эх дэлхийн өдөрт зориулж 11-р ангийн сурагчид “Дэлхийд тулгамдсан асуудлууд” сэдвээр бүтээлийн үзэсгэлэн гаргасан. Үзэсгэлэнг 23-р сургууль болон Чингэлтэй дүүргийн 8 сургуулийн 30 багш, 50 сурагчдад толилуулсан.

Хүүхэд нэг бүрийг хөгжүүлсэн байдал /Улс нийслэл, дүүрэг, сургууль/  
Газарзүйн судлагдахууны хүрээнд газарзүйн хичээлд сонирхолтой сурагчдыг уралдаан тэмцээнд хамруулж дараах амжилтуудыг үзүүллээ.  
-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, ШУТИС-аас зохион байгуулсан “Өсвөрийн геологич” улсын олимпиадад багаар оролцож II байр  
-Чингэлтэй дүүргийн Газарзүйн судлагдахуунаас зохион байгуулсан “Сонирхолтой газарзүй, Центавр” танин мэдэхүйн тэмцээнд багаар оролцож III байр эзлэв.

Олимпиад уралдаан тэмцээн  
Чингэлтэй дүүргийн газарзүйн олимпиадыг 2019 оны 03.16-ны өдөр 23-р сургууль дээрээ БУЗАН-ийн хамт олныхоо хамт амжилттай зохион байгуулсан бөгөөд тус олимпиадаас 10б ангийн сурагч Баярсайхан алт, 11а ангийн сурагч Арман хүрэл, 10а ангийн сурагч Одбаяр, 10г ангийн сурагч Эрмүүн, 9в ангийн сурагч Энхжин нар тусгай байр эзэлсэн.

Бүтээлч ажил

Даасан ангийн тухайд: Хүүхэд нэг бүрийн оролцоог хангаж анги нийтээрээ хөгжсөн байдал

Авьяаслаг 23 наадамд ангийн 52 сурагчаа жигд хамруулан урлагийн 9 төрлөөр амжилттай оролцож 7 дугаар ангийн бүлгүүдээс тусгай байр эзэлсэн.

2019 оны 05-р сарын 6-10-ны хооронд Хэлний наадмын үйл ажиллагаанд анги нийтээрээ идэвхтэй оролцож Ази хэлний өдөрлөгт Японы Анимэ баатар зурах, оригами хийх, үндэсний хувцас өмсөж угтах үйлчилгээнд оролцох зэрэгт ангиараа идэвхтэй оролцсон.

Багш ажлын байран дээрээ хөгжсөн байдал

2018-2019 оны хичээлийн жилийн I улирлын амралтаар сургууль дээрээ MOODLE системийн сургалтанд хамрагдаж, шалгалтанд хамрагдаж 100% үнэлгээтэй дүгнэгдсэн.

### III. Боловсролын сэтгэл ханамж

1. Цаг ашиглалт  
Сургууль болон дүүргээс зохион байгуулж буй ажилд идэвхтэй оролцдог.
2. Сэтгэл ханамжийн судалгааны дүн

Чингэлтэй дүүргийн хэмжээнд сургалт зохион байгуулж сургалтанд оролцсон 30 багш, 50 сурагчаас сэтгэл ханамжийн судалгаа авахад сэтгэл ханамж 99%-тай байлаа.

3. Хичээлийн цагийн хариуцлага-40 минут  
Хичээлийн хуваарийн дагуу цагийн алдагдалгүй ажилласан.
4. Багшийн ёс зүй, хууль эрх зүйн биелэлт  
Нийгмийн ажилтантай ёс зүйн гэрээ байгуулж, хууль журмын дагуу ажилласан.
5. Багшийн хичээлийн бэлтгэл  
Хичээлийн бэлтгэлийг хангаж Moodle системд агуулгаа оруулснаас хичээлийн хэрэглэгдэхүүн, цахим үзүүлэн, дасгалын зураг, газарзүйн зураг, атласыг хичээлдээ ашигладаг.
- ❖ Хоцрогч таслагч сурагчидтай ажилласан байдал хүрсэн үр дүн  
Хичээлийн жилийн эхэнд ангийн сурагчдын дунд хоцролт, таслалт байсан. Энэ байдалд дүгнэлт хийн эцэг, эхчүүд болон сурагчдад шаардлага тавин, өглөө бүр ангидаа эртлэн ирж 21 хоногийн хугацаанд “30 минутын үнэ цэнэ” арга хэмжээг явуулж ажилласнаар 11-р сарын аварга анги, хагас жилд гутгаар байр, III улиралд тэргүүн байр болсон байна. Мөн хамгийн хоцрогдолтой байгаа хичээлээ тодорхойлон яагаад хоцрогдол гарч байгаагаа судалсны үр дүнд 11 дүгээр сарын 28-наас 12 дугаар сарын 12-ныг хүртэл 2 долоо хоногийн хугацаанд өглөө бүр 07 цаг 20 минутаас ирж 8 цаг хүртэл 30 МИНУТЫН ҮНЭ ЦЭНЭ сэдэвт аяныг өрнүүлсэн бөгөөд энэ хугацаанд Япон хэлний N5 түвшний шалгалтанд бэлтгэх, Мэдлэг чадварын сорил авах Газарзүй, Математик, Монгол хэл, Түүхийн хичээлдээ бэлдэж байсан. АУБ-аас гадна Англи хэлний багш С.Мягмарсүрэн 3 удаа өглөө эртлэн ирж давтлага өгсөн.
6. Багш сургалтын ажлын баримт бичгийг зохих журмын дагуу хөтөлж байгаа байдал  
Багшийн үндсэн бичиг баримт болох багшийн журнал, анги удирдсан багшийн дэвтэр, сурагчийн хувийн хэргийг бичсэн.
7. Сургалтын техник хэрэгслийг ашигласан байдал  
Хичээлийн агуулга болон үнэлгээний даалгаврыг Moodle системд оруулан, 11-р ангийн “Байгаль нийгмийн хамаарал” нэгж сэдвийн хүрээнд ppt хичээлүүдийг бэлтгэн хичээл сургалтандаа ашигласан.
8. Сурагчдын хөгжил төлөвшил эрсдэлийн судалгааны сан бүрдэлт Ангийн зорилтот бүлгийг ьж  
н сурагчдын судалгааг гарган эцэг, эхчүүдтэй хамтран ажиллаж байна. Мөн 7б ангийн нийт сурагчдаас Эрсдлийн бүлгийн судалгааг авч дунд эрсдэл бүхий сурагчдыг анхааран ажилаж байна.
9. Хяналтын хуудасны хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийсэн байдал

**Эрүүл мэнд**

Сургуулийн Эко клубд ангиасаа 3 сурагчийг хамруулсан. Үүнд: Балжинням, Нандин-эрдэнэ, Хулан нарын сурагчид Бордооны багт орж ажиллан хүнсний хаягдлаар бордоо бэлтгэх нийслэлийн 5 сургуулийн дунд зохион байгуулсан уралдаанаас II байр эзэлсэн.

Завсарлага бүрээр салхивчаа онгойлгож агаар солилцоо явуулж байхыг тогтмол шаардсаны үр дүнд хичээл ордог ангиуд маань энэ үйлдлийг хэвшүүлж эхэлсэн. Ялангуяа 8а, 9в, 9д, 11а ангиуд тогтмол агаар оруулж угтдаг болсон.

Самбарын алчуур цэвэрхэн, элдэв үнэргүй байхыг тогтмол шаардсаны үр дүнд ангиуд алчуураа цэвэрхэн, чийгтэй байлгадаг. Дор бүрдээ хог хаялгүй цэвэр орчинд суралцахыг тогтмол зөвлөж шаардлага тавьдаг.

Сүүлийн цагийн хичээл орсон ангийн сурагчиддаа замын хөдөлгөөнд анхаарал болгоомжтой оролцох, олон нийтийн газар биеэ зөв авч явахыг сануулан хэлж хэвшсэн.

Цэнэглэх цаг “Эрүүл мэнд, гоо сайхан” үр дүнд сургуулийнхаа 10 багштай хамтран Spining сургалтанд 3 сарын хугацаанд хамрагдан өөрийгөө хөдөлгөөний дутагдлаас хамгаалан эрүүл мэнддээ анхаарлаа.

2019.05.06-ны өдөр Цэнэглэх цаг “Эрүүл шүд-эрүүл хүүхэд” сургалтанд сууж ангийн сурагчдад дүүргийн шүдний эмнэлгүүдэд үзүүлэхийг зөвлөв.

2019.05.11-ны өдөр “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийн хүрээнд хамт олноороо 50 ш нарс модыг суулгах ажилд оролцов.

#### **Ангийн сурагчдын төлөвшил:**

Ангийн сурагчдад сургуулийн дэгийг хэвшүүлэх, хоцролт таслалтгүй хамт олон болох чиглэлээр ажиллаж байна. Тухайлбал 9 дүгээр сард 14 байсан бол 10-р сард 9 сурагч байсан бол анхаарч ажилласнаар 11 дүгээр сард Дэд байранд шалгарсан амжилт үзүүлсэн.

#### **ОРОЛЦОО:**

- ✓ *Газарзүйн хэлээр ярьж, газарзүйн зураг унших анхны мэдээгдэхүүн эзэмшиж, масштабын бодлолго бодож, дасгал ажлын зураг зурах чадвартай болох. Мөн өөрийгөө зөв гүйцэт илэрхийлж сурах:*

8 ангийн сурагчдын том масштабын газарзүйн зураг унших чадвар 40%, газарзүйн хэлээр ярих чадвар 50%, масштабын энгийн бодлого бодох чадвар 90 %, дасгал ажлын зурагт ажиллах чадвар 70% байна гэж дүгнэж байна. Хурдан уншиж, зөв ойлгох, таамаглах чадвар харилцан адилгүй байдаг.

8а ангийн сурагчид харьцагуй хурдтай, хичээлд хандах хандлага сайтай, бие даах ажлыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэдэг. 8б ангийн ерөнхий төлөвшил сайн боловч хичээл хийдэггүй залхуу 4-5 сурагч байна.. 8в ангийн сурагчид жигд хурдтай, анхааралтай сонсож төвлөрсөн үедээ үйл ажиллагаа чанартай хурдан байдаг ч бүх сурагчийн ороцоо тэр бүр 100% байж чаддаггүй . 8г ангийн эрэгтэй сурагчдын 30% сууж сураагүй ажилдаа төвлөрч чаддаггүй нь бусад сурагчдын үйл ажиллагаанд саад учруулж байдаг. 8д ангийн хувьд сурагчдын идэвх оролцоо өмнөх хичээлийн жилээс буурсан. Нийт сурагчдын дунд залхуу, хэнэггүй, өөрийгөө дайчилдаггүй, анхаарлаа төвлөрүүлж чаддаггүй сурагч цөөн биш байна.

- ✓ *Газарзүйн зураг уншиж, харьцуулан дүгнэж, учир шалтгааныг таамаглан, тодорхой түвшинд баталж сурах, газарзүйн бодлого бодох, зүг чиг тодорхойлж, солбицол олж сурах. Монгол орны байгаль нийгмийн*

*харилцан хамаарлыг таамаглан, судлах явцдаа өөрийгөө зөв гүйцэт илэрхийлж сурах. Шинжлэх ухаанч арга барил эзэмших*

9 а,в, д ангийн сурагчдын идэвх оролцоо сайн, гэрийн даалгаврыг сайн гүйцэтгэдэг, хандлага зөв сурагчид олонтой. Хичээлийн 40 минутын хугацааг үр дүнтэй бүтээлч өнгөрүүлж чаддаг болсон сурагчдын тоо нэмэгдсэн төдийгүй мэдлэг чадварын сорил шалгалтанд сайн бэлтгэсэн.

Анги бүрт 5-7 сурагч маш залхуу, анхаарлаа төвлөрүүлж чаддаггүй, өөрийгөө дайчилдаггүй бөгөөд анги удирдсан багшид мэдээлэл өгч хамтран ажиллаж байна.

✓ *Газарзүйн зургууд болон өгөгдсөн мэдээллүүдийг унших, харьцуулах, таамаглал дэвшүүлэх, таамаглалаа батлах, өгөгдсөн тоо баримтаар янз бүрийн зураглал хийж дүгнэлт гаргах, агуулгыг хүснэгт, схем, оюуны зураглалын аргаар бичиж тэмдэглэх. Илтгэх, тайлбарлан таниулах чадварт суралцах шинжлэх ухаанч арга барилуудаа сайтар эзэмших*

11а ангийн сурагчдын идэвх оролцоо, хичээлд хандах хандлага боломжийн, явцын үнэлгээ болон нэгжийн шалгалтуудыг амжилттай өгсөн. Дэлхийн улс төрийн зураг болон дасгалын зураг дээр амжилттай ажиллан бүтээлийн үзэсгэлэн гаргасан. Сурагчид хичээлийн жилийн эхэнд багт хуваагдан судалгааны ажил болон, бие даах ажлын хавтас гаргасан бөгөөд байнг баяжилт хийн ажиллаж байгаа. 10-р сарын

Цаашид бие даан судалгаа хийж, судалгааны ажлын арга барилд сургахаар ажиллана.

#### **ДАДАЛ ХЭВШИЛ:**

✓ *Цагийн ажлыг цагт нь хийж хэвших, дэвтрийн үйл ажиллагаа тогтмол жигд байх, гэрийн даалгавраа цаг тухайд нь тогтмол хийх:*

Хичээлийн жилийн эхэнд “цагийн ажлыг цагт” нь гэсэн уриа дэвшүүлэн хичээл орох бүрт гэрийн даалгавар, ангийн ажил, дэвтрийн үйл ажиллагаагаа шалгуулж хэвшсэн. 8, 9 дүгээр ангийн сурагчдын 75-80 хувь нь хичээлээ тогтмол тэмдэглэн, даалгавраа цагт нь шалгуулж хэвшлээ. Нөхөж гүйцэтгэсэн ажлыг тооцохгүй байхаар тохирсон нь энэ үр дүнд хүрэхэд тодорхой нөлөө үзүүлсэн.

Сурагчид хичээлийн хэрэгслээ бүрэн хангаж ирэх, ашиглаж хэвшихийг тогтмол шаардаж байгаагийн үр дүнд 8-9 ангийн сурагчдын сурах бичиг ашиглалт 85-90%-тай байна.

#### **ЗАН ЧАНАР:**

✓ *Багш сурагчид харилцан бие биенээ хүндэтгэн харилцаж, мэндлэх хүндлэх ёсыг эрхэмлэн, бие биенээ хүлээцтэй сонсож, өөрийн үзэл бодлоо бусдад зөв илэрхийлэж сурах:*

Зан төлөвийн гажуудалтай сурагч байхгүй. Багштай байнга мэндлэн хүндэтгэлтэй ханддаг. 8, 9 ангийн зарим сурагчид сургалтын явцад бусдад саад болдог ч нэгэндээ шаардлага тавьж, тавьсан шаардлагыг хүлээн авч сурч байгаа.

8б ангийн нийт сурагчдын, хэсэгчилсэн болон ганцаарчилсан ажиглалт судлагаа хийж, ангид үзүүлж эерэг нөлөөг нэмэгдүүлэх, сөрөг нөлөөг багасгах арга хэмжээ авч ажиллаж байна. Тэдгээр сурагчидтай ярилцлага хийн, анхааруулга, зөвлөгөө өгч, амлалт авч дахин дутагдал гаргахгүй байхыг санууллаа. 12 дугаар сарын суурь боловсролын 7-9 дүгээр ангиудын БАГШ НАРЫН ЗӨВЛӨГӨӨН-ий хуралд сууж сурагчдад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн.

### **3.5 АВЪЯАСЫГ НЭЭН ХӨГЖҮҮЛСЭН БАЙДАЛ**

#### **ЭКО ЗӨВЛӨЛИЙН ХҮРЭЭНД:**

2018-2019 оны хичээлийн жилийн 10 дугаар сараас GREEN ISLAND төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа олон улсын Эко сургууль хөтөлбөрт хамрагдан сургуулийн эко зөвлөлийн гишүүнээр ажиллаж 3 удаагийн сургалтанд хамрагдан сургалтаа сургуулийн хүрээнд багш нарт 2 удаа сурагчдад 3 удаа түгээн дэлгэрүүлж, сургуулийн Эко зөвлөлийг шинэчлэн 42 сурагчийн бүрэлдэхүүнтэй байгуулан Улаанбаатар хот, Чингэлтэй орон нутгийн орчны төлөв байдлын үнэлгээ, хөрсний шинжилгээ болон 23-р сургуулийнхаа орчны үнэлгээг хийхэд багш сурагчидтай багаар ажиллан, үйл ажиллагаа явуулж байна. Эко зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа 11б ангийн сурагч Энхсарнай, 11в ангийн сурагч Дэлгэрмаа, 11д ангийн сурагч Алтансүвд, Номин, Гүнболор нарын сурагчид нь Эко сургалтын сургагч багшаар бэлтгэгдэн олон үйл ажиллагаанд биечлэн оролцон сургалтууд зохион байгуулж ажиллаж байна.

### **3.7 ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДАЛ**

#### **4. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖ**

Багш нар, сурагчид, эх эцэг-асран хамгаалагч, бусад ажилтан албан хаагчидтай багшийн ёс зүйг баримтлан, хүндэтгэлтэй харилцдаг. Багш, эцэг эх, сурагчийн гурвалсан гэрээг байгуулан баталгаажуулж баримтлан ажиллаж байна.

Сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт шинэчлэлийн асуудал, сурагчдын сурлага хүмүүжлийн талаар, төдийгүй өдөр тутмын сургалтын үйл ажиллагаа хөндлөнгийн ба явцын шалгалтын зэрэг мэдээллийг багш, хамт олон, эцэг эхтэй чөлөөтэй ярилцан харилцан суралцаж байна. 8б ангийн эцэг эхийн хурлыг 3 удаа зохион байгуулж боловсролын үйлчилгээний тухай мэдээллээр ханган, ангийн сурагчдын үйл ажиллагааны тайланг танилцуулж цаашид хамтран хийх үйл ажиллагаагаа харилцан ярилцлаа.

Эцэг, эхийн 4 багт хуваагдан 1 ба 2-р багууд хичээлээс гадуурх үйл ажиллагаа (МҮОНТҮ-тэй танилцах аялал), Авъяаслаг 23 наадамд оролцох, Шинэ жилийн үйл ажиллагааг зохион байгуулах зэрэгт идэвх зүтгэл гарган оролцсон.

#### **5. БАГШИЙН ХӨГЖИЛ**

- ✓ Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүй сургалт – 2018.08.29-30
- ✓ Олон улсын эко сургууль хөтөлбөрийн анхан шатны 1 дэх сургалт – 2018.10.19-20
- ✓ Нийслэлийн зөвлөх багийн уулзалт, сургалт. 2018.11.20
- ✓ Даалгаврын сан хөгжүүлэх БҮТ сургалт– 2018. 11 .21
- ✓ Олон улсын эко сургууль хөтөлбөрийн анхан шатны 2 дэх сургалт – 2018.11.8-9
- ✓ Олон улсын эко сургууль хөтөлбөрийн анхан шатны 3 дэх сургалт – 2018.12.14-15
- ✓ Цэнэглэх цаг (6 удаа хамрагдав.)
- ✓ Spining сургалт

Эко сургууль хөтөлбөрийн АЛСЫН ХАРАА

Эко сургуулийн 7 алхамт аргачлалын хүрээнд 11 сэдвээс СУРГУУЛИЙН

ОРЧИН,ХОГ ХАЯГДАЛ гэсэн сэдвийг тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдуулан сургууль дээрээ хэрэгжүүлэн ХҮРЭЛ ГЭРЭГЭ болзол хангах, цаашид НОГООН ТУГ-тай сургууль болох

## **6. ДҮГНЭЛТ:**

2017-2018 оны хичээлийн жилд нийт 14 бүлгийн 660 сурагчид газарзүйн хичээл орж хамтран судлаж, ажиллан үнэлгээ хийв. Сурагч нэг бүрийг хөгжүүлэх, дэмжих үнэлэх ажлыг тооцоо судалгаатай хийж ажилласан. Үүний үр дүнд сурагчдын хичээлд хандах хандлагад өөрчлөлт гарч хичээлийн бэлтгэлээ хангаж ирэх, гэрийн даалгавраа хийдэг сурагчдын тоо эрс нэмэгдсэн ба сурлагын чанарт ахиц гарсан.

Сурагчид хийснийхээ хирээр үнэлүүлж эхэлсэн нь цагийн ажлыг цагт нь хийж гүйцэтгэх, тодорхой зорилготой болоход нөлөөлж байгаа гэж дүгнэж байна.

Ахлах ангийн сурагчид бие даан ээлжит хичээлд бэлтгэн, хичээл удирдах үйл ажиллагаа зохион байгуулахад сурагчид сайн хамрагдсан ба хийсэн ажлын гүйцэтгэл харахан бүрэн болж чадаагүйд дүгнэлт хийн газарзүйн дадлага ажил хийх, харьцуулан дүгнэлт гаргах, учир шалтгааныг тайлбарлахад түлхүү анхаарч ажиллахыг хичээж байна.

Танхимын сургалтаас гадна хичээлээс гадуурх үйл ажиллагаанд сурагчдыг татан оролцуулах, оролцоог нэмэгдүүлэх, нийгмийн тустай ажилд татан оролцуулах чиглэлээр ажиллаж байна. Тухайлбал: 11 дүгээр ангийн 35 сурагчийн хамт Сэлбэ голын урсац тодорхойлох, голын сав дагуу хогийг цэвэрлэх экскурс судалгааг хийсэн. Мөн Олон улсын эко сургууль хөтөлбөрийн хүрээд сургуулийн эко зөвлөлд орж ажиллаж, сургууль болон дүүргийн хэмжээнд 5 удаагийн сургалт зохион байгуулж, Ротаричуудын өдөрлөгт Э-Гоми төслийг багаараа танилцуулж төслийн санхүүжилт авч сургуульдаа 2 250 000 төгрөгийн хөрөнгө оруулалт оруулж, гадна талбайн хогийн савыг байршуулаад байна. Мөн сургуулийнхаа үйл ажиллагаанаас гадна НБГ-ын зөвлөн туслах багшийн гишүүнээр ажиллаж 11-р ангийн анги дэвших шалгалтын жишиг даалгавар боловсруулж, Багануур дүүрэгт зөвлөн туслах чиглэлээр ажиллалаа. Мөн МУБИС дээр ЭЕШ-нд бэлтгэгчдэд сургалт зохион байгуулсан.

## ХАВСРАЛТ



Олон улсын Эко сургууль хөтөлбөрийн анхан шатны сургалт  
Сургуулийнхаа хөрсний шинжилгээг хийв. 2018.10.19-20



Шинэ Монгол сургууль 2018.11.15-16-ны өдрүүдэд анхан шатны 2 дахь сургалт



Сэлбэ голын сав дагуу хогийг цэвэрлэж, урсацыг тодорхойлох экскурс судалгаа



Эко клубын сурагчид хүнсний хаягдлаар “Бордоо бэлтгэх” уралдаанд орж нийслэлд 2-р байранд шалгарав.



2018.12.14-15-ны өдрүүдэд Наран сургууль дээр олон улсын эко сургууль хөтөлбөрийн 3 дахь шатны сургалт



Хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний төвтэй хамтран Эко клубын 30 сурагчид сургалт зохион байгуулав.



Сургуулийнхаа нүүрстөрөгчийн ул мөрийг тодорхойлох судалгааг хийв.

Төслийн нийт санжүүжилт - 2'250'000 төг





д/д	Нэр	Хэмжээ	Материал	Нэгж	Материал	Өнцөг	Нийт үнэ	Гүйцэтгэгч
1	Ангилсан хогийн цэг	1	3500x2000x1500	Төмөр сарвалж	1500000 төг	Торон лист	саарал 1 500 000төг	
2	Холмог хогийн цэг	1	1500x2000x1500	Төмөр сарвалж	520000	Торон лист	саарал 520 000төг	"БЧГ" ХХК
3	Танх тэмдэг мэдээллийн санбар		Танх тэмдэг Санбар	3x15000x45000 2x92500x185000			230 000 төг	
							Нийт мөнгөн дүн	2 250 000төг

Бидний хүсэж буй гадна талбайн хогийн цэг

Ротаричуудын өдөрлөгт танилцуулсан Э-гоми төсөл 2019.03.16



ЧД-ийн Газарзүйн олимпиадыг БУЗАН-ын хамт амжилттай зохион байгуулав.



“Эрэг болгоё” аяны хүрээнд гаргасан ханын самбар

## Сурагчдын оролцооны амжилт



МУБИС-н Газарзүйн тэнхимийн нээлттэй хаалганы өдөрлөгт 12а ангийн 5 сурагч ЭЕШ-н давтлагад үнэ төлбөргүй хамрагдах, ЭЕШ-д 400 –с дээш оноо авбал элсэн орох эрхээр шагнагдлаа.

Activate Windows  
Go to Settings to activate Windows.

## Сурагчдын оролцооны үр чадварын хөгжил




“Өсвөрийн геологич” Улсын олимпиадад дэд байранд шалгарлаа.



Чингэлтэй дүүргийн ЕБС-н сургуулиудын Газарзүйн центавр уралдаан



Центавр уралдаанд амжилттай оролцож III байрт шалгарав.



Эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлсэн байдал:

1.ЭЭЗ дарга илтгэлээ хэлэлцүүлэв.

2.Сурагчид багийн ажлаа танилцуулав.

3. Япон хэлний багш нартай уулзалт зохион байгуулав. 2019.06.13





2019 оны 04.22 Эх дэлхийн өдөрт зориулж сурагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргав.



Ангиараа Жамбалсүрэнгийн Золбаярын “Амьдрал сайхан шүү” номыг уншив.



76 ангийн сурагчид АЗИ ХЭЛ-ний өдөрлөгт






Бүх нийтээр МОД ТАРИХ ӨДӨР



ЧД-ийн 8 сургуулийн 30 багш, 50 сурагчид “ТХ-д сурагчдын оролцоо, хог хаягдлыг ангилан ялгах” сургалтыг ЭКО Зөвлөл-ийн хамт зохион байгууллаа.



МУБИС дээр ЭЭШ-д бэлтгэгчдэд зориулсан сургалт зохион байгуулав. 2019.06.10

